

4.ЁС ЗҮЙ

Интернетийн ёс зүйн асуудалд

Доктор З.Болд. Р.Дарьхүү.Т.Дорждагва

Түлхүүр үг : Мэдээллийн ертөнц,мэдээллийн ёс зүй,
интернетийн ёс зүй , деонтологи, утилитаризм,

Интернетийн ёс зүй бол мэдээллийн аюулгүй байдлыг хангах нэг үндэс мөн. Энэхүү ёс зүй нь мэдээллийн технологи ба норматив ёс зүйн уулзвар дээрхи судалгааны талбар юм. XXI зуун бол мэдээллийн зуун бөгөөд дэлхийн мэдээллийн технологийн зах зээл асар хурдтайгаар хүрээгээ тэлж байна. Энэ зуунд дэлхий дахинд мэдээллийн хувьсгал нь банк, санхүү, үйлдвэрлэл, хөдөлмөр, эмнэлэг, тээвэр гэхчилэн бүхий л салбарын салшгүй бүрэлдэхүүн хэсэг болжээ.Мэдээллийн технологийн үсрэнгүй хөгжил XXI зууныг тодорхойлох болсон энэ үед нийгэм, улс төр, эдийн засгийн амьдралыг интернетгүйгээр төсөөлөх аргагүй болов. Хориодхон жилийн өмнө зөвхөн цэрэг стратеги болон тодорхой мэргэжлийн салбарт ашиглаж байсан сүлжээ нь өнөөдөр дэлхийг аалзны торноос ч нарийн нягт мэдээллээр холбосон өргөн сүлжээ болтлоо өргөжиж байна.

Анх 1990 онд АНУ-ын Конгресс интернетийн сүлжээг олон нийтэд өргөн ашиглуулах эрх олгожээ. Тэр үеэс л Америк болон Баруун Европын улсууд энэ сүлжээг өргөн ашиглаж иржээ. Анхандаа зөвхөн мэдээлэл дамжуулах, захиа бичилцэх зорилгоор хэрэглэж байсан бол одоо энэ сүлжээний боломжийг бүрэн ашиглаж, интернетийн үзвэр, үйлчилгээ, үйлдвэрлэл, бүтээгдэхүүнийг хүртэл бий болгожээ.Ийнхүү интернет үүсэнтэй холбоотойгоор Кибер-этик гэдэг нэр томьёог бас өргөн хэрэглэж байна.Энэ нь зөвхөн мэдээлэл зүйтэй холбоотой ёс зүйн асуудлаас илүүтэй олон нийтийн мэдээллийн хэрэгслийн /масс-медиа/ хүрээнд асуудлыг өргөтгөн үзэх болсонтой холбоотой билээ.

Интернет хэмээх хүн төрөлхтөний гайхамшигт зүйл нь олон талын үр өгөөжтэй зүйл билээ. Гэвч бас сөрөг үр дагавар ч байна. Тухайлбал, хууль бус сурталчилгаа, терроризм, алан хядлага, хүчирхийлэл, садар самууныг сурталчилсан олон ВЭБ сайт бий болж, улс нийгэмд, хүүхэд залуучуудын хүмүүжилд сөрөг мэдээллийн аюулыг өсгөж байна.

Манай улсын хувьд 1995 оноос интернетийн сүлжээг оруулж ирсэн бөгөөд МН домэйн бүхий анхны ВЭБ нь www.mol.mn (Mongolian online) юм. 2000 оноос хойш интернетийн хэрэглээ эрчимтэй өсөж, Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийг холбосон томоохон сүлжээний кабелиуд тавигджээ. Ийнхүү нийгэм-эдийн засгийн харилцаа холбоо технологийн хөгжлийг дагаад интернетийн орчин сайжирч, хүн амын дотор интернет хэрэглэгчдийн тоо улам өссөөр байна. Одоо нийт интернет хэрэглэгчдийн 67 хувь нь интернет кафе-гаар, 33 хувь нь ажлын байранд, эсвэл гэртээ интернетийг хэрэглэж байна. Өөр нэг онцлог бол интернет хэрэглэгчдийн ихэнх нь өсвөр үеийнхэн, залуучууд байгаа явдал юм.

МН домэйн бүхий олон ВЭБ сайт нь зохиогчийн эрх зөрчих, эм, архи, тамхи гэх мэт хуулиар сурталчлахыг хориглосон бараа бүтээгдэхүүнийг сурталчлах болов. Интернет өөрөө хуулийн этгээд биш ч, интернетийг ашиглаж буй ВЭБ нь өөрөө хуулийн этгээд мөн.

Өнөөдөр та бидний үр хүүхэд садар самуун, хүчирхийлэл, алан хядлага, ёс суртахуунгүй үйлдлийг энгийн түвшинд хүлээж авах нөхцөлд өсөж, хүмүүжиж байгааг анхаарч, энэ талаар тодорхой судалгаа хийж, асуудлыг нэн даруй шийдэх цаг болжээ. Зарим хүмүүсийн хувьд интернетэд орох нь өглөөний цайнаас илүү чухал хэрэгцээ болжээ. Интернет хар тамхи шиг хүнийг

донтуулдаг интернетийн элдэв сонин мэдээ, мэдээлэлд хэт татагдаж, ажлаа мартах, нойроо хасах, хичээлээс хөндийрөх асуудлууд ч байна.

Саяхан Голланд улсад компьютер, тоглоомын дон туссан хүмүүст зориулсан анхны эмнэлэг нээгджээ. Эндээс үзвэл, компьютер тоглоом нь гэмгүй санагддаг боловч архи ба мөрийтэй тоглоомын адил хүнийг донтуулдаг байна. Компьютер тоглоомонд донтсон зарим залуучуудын сүүлийн 3 жил харьцсан хамгийн дотно хүн нь хэдэн мянган километрийн цаана өөр улсад бас компьютерийн ард суудаг нэгэн байдаг нь баримт ч байна.

АНУ болон Канадад компьютерийн өвчнийг эмчилдэг 12 эмнэлэг байдаг бол Хятадад энэ төрлийн сувилал ажилладаг байна. Дэлхий даяар компьютер хэт их тоглох нь өвчин гэж хүлээн зөвшөөрөгдсөн ажээ. Зарим хүүхэд, залуучууд өдөрт 10-14 цаг тоглодог, ухаан алдаж унатлаа тоглодог байна. Ийм өвчин нь хүүхэд бусад бүх зүйлийг хайхрахгүй байгаагаар илэрч эхэлдэг гэнэ. Хүүхэд залуучууд 1-2 цаг тоглоод гэрийн даалгавраа хийнэ хэмээн компьютерийн ард суудаг боловч нэг тоглож эхлэхээрээ бусад бүх зүйлээ мартдаг аюултай.

И- мэйл болон чат нь хамгийн хямд үнээр харилцах нэг чухал хэрэгсэл юм. И-мэйл, чат зэрэг нь харилцагч хүнтэйгээ нүүр нүүрээ тулж харьцдаггүй учраас эерэг болон сөрөг талтай байдаг. Эерэг тал нь бүрэг, ичимхий хүмүүс шууд хэлж чадахгүй асуудлыг шийдэхэд дөхөмтэй, мөн хямд үнэтэй, нөгөө хүнийхээ зав гарахыг хүлээхгүй, хэлэх зүйлээ бичээд үлдээчихдэг гэх мэт. Харин сөрөг тал нь цаад хүнийхээ хэрхэн хүлээж авч байгаа сэтгэл санааны байдал, царай төрхийг мэдэх боломжгүй. Гэвч түүнийг ашиглахад ёс зүйн хувьд анхаарах зүйл их бий. Тийм ёс зүйг мэддэггүйгээс, эсвэл мэддэг ч дагаж мөрдөггүйгээс болж манайхан и-мэйл, чатыг ёс бус, замбараагүй хэрэглэх хандлага ажиглагдаж байна. Энэ талаар компьютерийн ёс зүйг үндэслэгчдийн нэг Д. Паркер "Мэдээллийн ёс зүй"¹⁴⁶ хэмээх бүтээлдээ тэмдэглэхдээ: "Хүмүүс интернетед орж ирэхдээ үүдэнд нь ёс зүйгээ орхиод ороод ирсэн мэт харагддаг" гэжээ.

Иймд бид сүлжээний ёс зүйн хэм хэмжээг боловсруулж, чанд сахих хэрэгцээ, шаардлага өсч байна. Ер нь сүлжээний ёс зүй гэдэг бол олон улсад маш чухлаар тавигддаг байна. Сүлжээний ёс зүйн энгийн дүрмүүдийг мэдэж байх нь чухал. Үүнд: хүмүүс уулзахдаа эхлээд мэндэлдэг хүндэтгэлийн сайхан ёс бий. Сүлжээнд ч энэ бичигдээгүй хуулийг мөрдөж, эхлээд заавал монгол хэлээр мэндлэх хэрэгтэй. Харилцагчаа хүндэтгэх үүднээс бүдүүлэг үг хэллэг, гудамжны яриа, хараалын үг хэрэглэж болохгүй. Өөрийгөө товч, тодорхой танилцуулах, хэрэгтэй. Өөрийн нэр, албан тушаал, ажлын газрын утас, и-мэйл хаягийг бичих нь зүйтэй. Харилцагч хүнийхээ цагийг хайрлаж аль болох товч, тодорхой, үнэн зөв мэдээ, мэдээлэл солилцох, мөн эх хэлээ зөв хэрэглэх нь чухал. Энэ бүх хэрэгцээ шаардлагыг үндэслэн бид компьютер хэрэглээний ёс зүйд анхаарах цаг болжээ гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, компьютер хэрэглээний ёс зүй нь компьютерийн ёс зүйн нэг тулгамдсан асуудал юм.

Тэгвэл, компьютерийн ёс зүй гэж юу вэ? Компьютерийн ёс зүйн үүсэл, хөгжил, түүний үндсэн асуудлууд, компьютер хэрэглээний ёс зүйн үндсэн хэм хэмжээ ямар байх ёстой вэ? зэрэг асуудлыг энэхүү өгүүллийн хүрээнд асуудал болгон тавьж байна.

Өрнө дахинд компьютерийн ёс зүй нь 1940-1950-иад оны үеэс үүсч хөгжиж иржээ. Анх АНУ-ын профессор Norbert Wiener¹⁴⁷ нь нийгэм болон хүмүүсийн амьдралд компьютерийн технологийн үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллүүдийг судлаад, компьютер нь бараг бүх төрлийн ажлыг хийж чаддаг төгс багаж хэрэгсэл, компьютер нь ядрахгүй, унтахгүй, чөлөө авахгүй, гэртээ харих шаардлагагүй, эдийн засгийн үүднээс ажиллах хүчийг орлох боломжтой,

¹⁴⁶ Donn Parker. Information Ethics. 1968

¹⁴⁷ Norbert Wiener. The Human Use of Human Beings. USA. 1950

олон шинэ мэргэжил, ажлын байр бий болгосон зэрэг олон эерэг талыг дурьдахын зэрэгцээ бас сөрөг талуудыг ч тодорхойлсон буй. Тухайлбал, компьютерийн ажлын байран дахь ажиллагсадын эрүүл мэндийн асуудал: монитороос ялгарч буй туяаны хорт нөлөөлөл, нүдний хараа муудах, стресс, мэдрэлийн ядаргаа, хөдөлгөөний хомсдол, нуруу болон гарын үе муруйх, компьютер тоглоомонд донтох, мэдээллийн бохирдол гэх мэт.

Компьютерийн ёс зүйн асуудлуудыг нэг талаас, мэргэжлийн философичид уламжлалт ёс зүй (норматив ёс зүй)-н онолууд болох утилитаризм, деонтологи онолын үүднээс үндэслэн боловсруулж, нөгөө талаас мэдээллийн технологи, компьютерийн мэргэжлийн стандартууд, компьютерийн хэрэглээний талаас компьютер технологийн мэргэжилтнүүд өргөн судалж боловсруулсан байна. Өөрөөр хэлбэл, норматив ёс зүй ба компьютер мэдээллийн технологийн шинжлэх ухааны уулзвар дээр компьютерийн ёс зүй үүсч хөгжсөн түүхтэй юм.

1970-аад оны дундуур Америкийн судлаач У. Маннер компьютерийн ёс зүй хэмээх нэр томъёог анх шинжлэх ухаанд оруулж иржээ. Тэрээр Бентам ба Миллийн утилитаризм, Кантын деонтологи ёс зүйн үүднээс компьютерийн ёс зүйг боловсруулжээ. Түүний үзлээр, "Компьютерийн хэрэглээнээс болж ёс суртахууны байдал улам муудаж байна. Иймд компьютер хэрэглээний ёс зүйн зарчмуудыг боловсруулж, мөрдөх шаардлагатай. Компьютерийн ёс зүйн гол асуудал мэдээллийг боловсруулах, түгээх, хэрэглэх ёс зүйн хариуцлагын асуудал юм. Мөн энэ үеэс компьютерийн мэргэжлийг мэдээллийг боловсруулах хүрээнд ашиглаж эхэлсэнтэй холбоотойгоор эрдэм шинжилгээний болон техникийн баримт бичгүүдийг дижитал хэлбэрээр хадгалах хэрэгцээнээс мэдээллийн ёс зүй¹⁴⁸ үүссэн гэж үздэг. Мэдээллийн ёс зүй нь мэдээллийн буюу дижитал сүлжээний ертөнц дэх ёс суртахууны өөрчлөлт, мэдээллийн төлөв байдлыг тодорхойлогч хүчин зүйлсийн харьцааг тодорхойлох, анализ хийх, мэдээллийн бохирдлыг багасгах зэрэг шаардлагаар үүсчээ. Мэдээллийн ёс зүйд дижиталчлалтай холбоотой ёс зүйн бүх асуудлыг хамруулж болно. Жишээ нь, дэлхий дээрхи бүх үзэгдэл юмс, түүний дотор амьд байгалийг реконструкц хийх, мэдээллийг солилцох, мэдээллийг боловсруулах, ангилах, түгээх асуудлууд ордог байна.

Өнөө үед мэдээллийн сүлжээг чөлөөтэй болгох асуудлыг онцгойлон авч үзэх болов. Энэ нь бодит ертөнц дээр тэгш бус байдал, хүчирхийллийг сүлжээний ертөнцөд оруулахгүй байлгаж, сүлжээнд эдийн засаг, цэрэг зэвсэг, улс төр, техник, ёс суртахуун, шашны гэх мэт хүчирхийлэлгүй төлөв байдлыг төлөвшүүлэх тухай асуудал юм. Үүнтэй холбогдож дараах асуудлуудыг онцлон авч үзэж байна. Үүнд:

- Дижитал хуваагдлын асуудал
- Медиа ба компетенцийн асуудал
- Сайн агуулга ба бидний даган дууриах идеалын асуудал
- Интернет дэх мэдлэг, түүнийг зах зээлийн эргэлтэд хэрхэн оруулах хэн түүнийг эзэмших асуудал
- Мульти соёлын асуудал
- Мэдээллийн ертөнцөд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх ба тоглоомын дүрмийн асуудал
- Мэдээлэл ба аюулгүй байдлын асуудал зэрэг болно.

Д.Жонсон "Компьютерийн ёс зүй"¹⁴⁹ бүтээлдээ: Компьютерийн ёс зүйн салбарт хамаарах асуудал, ёс зүйн зарчим нь компьютер программ үйлчлэлийн үед гарсан алдаа болон хүлээх хариуцлага, компьютерийн техник,

¹⁴⁸ Informations ethic. Fine Standart festimmung Rapael Capurro. International Review of Information Ethics (IRIE) .2004.

¹⁴⁹ Deborah.G.Johnson. Computer ethics. 1985.

автоматжуулалтаас ажиллагсдын эрхийг хамгаалах, мэдээллийн болон сүлжээний ёс зүйн асуудлуудыг авч үзжээ. Тэрээр мөн компьютерийн ёс зүй нь орчин үеийн ёс зүйн нэг шинэ салбар болохыг тодорхойлжээ.

1990-ээд оноос компьютерийн хэрэглээ улам бүр өргөжиж, компьютер нь хүний амьдралын үнэт зүйлс болсон ёс суртахуун, эрүүл мэнд, эрх чөлөө, баялаг, ардчилал, хувийн нууц зэрэг олон зүйлст шууд нөлөөлөх болов. Ялангуяа мэдээллийг хянах боломж багасаж, мэдээллийн бохирдол ихэссэн нь мэдээллийн бохирдлын төлөө хүлээх хариуцлагыг дээшлүүлэх, компьютер хэрэглээний ёс зүйн шинэ хэм хэмжээ, зарчим боловсруулахыг шаардах болжээ.

Үүнтэй холбоотойгоор Д.Готтербарн¹⁵⁰ компьютерийн ёс зүй нь мэргэжлийн ёс зүйн нэг үндсэн салбар гэж үзжээ. Түүний үзлээр, компьютерийн ёс зүйн гол асуудал нь компьютер хэрэглэгчдийн ажлын стандарт, ёс суртахууны хэм хэмжээ, зарчмуудыг тодорхойлж, мөрдүүлэх явдал юм. Мөн компьютер үйлдвэрлэгчид, зохион бүтээгчдийн ёс зүй ч чухал гэжээ.

Компьютерийн мэргэжлийн ёс зүй бол компьютерийн мэргэжлийн үйл ажиллагаан дах зан үйлийг зохицуулах арга хэрэгсэл юм. Компьютерийн мэргэжлийн ёс зүйн ерөнхий зарчмууд гэвэл хүнлэг байх, шударга байх, ухаалаг байх, эвсэг нийтэг байх, хариуцлагатай байх, өөрийн болон бусдын нэр төрийг эрхэмлэх зэрэг болно. Харин компьютерийн мэргэжлийн ёс зүйн тусгай зарчмууд нь мэргэжлийн мэдлэг сайтай байх, мэргэжилдээ үнэнч байх, өөртөө өндөр шаардлагатай байх, зарчимч байх, мэргэжил нэгт хамт ажиллагсадаа хүндэтгэн харьцах зэрэг болно. Компьютер үйлдвэрлэгчид, зохион бүтээгчдийн хувьд хүний эрүүл мэндэд компютераас учруулах хор нөлөөг бууруулах, улмаар арилгах нь хүнлэг ёсны зарчимд нийцнэ.

Энэ бүхнээс үзвэл, компьютерийн ёс зүйн үндсэн асуудлуудад:

- Мэдээллийн ёс зүйн асуудал /сүлжээний ёс зүйн асуудал/
- Интернет хэрэглээний ёс зүйн асуудал
- Хувь хүний нууц ба эрх чөлөөний асуудал
- Зохиогчийн эрхийн ёс зүйн асуудал
- Мэргэжлийн хариуцлагын ёс зүйн асуудал
- Компьютерийн гэмт хэрэг зэргийг хамааруулах бололцоотой юм.

Эдгээр асуудлыг нарийвчлан судалж, сургалт сурталчилгаа хийх нь олон талын ач холбогдолтой юм. XX зууны сүүлч, XXI зууны эхэн үеэс дээрх асуудлуудын дотроос мэдээллийн ёс зүй, интернет хэрэглээний ёс зүй, компьютерийн мэргэжлийн хариуцлагын ёс зүйн асуудлууд илүү их анхаарал татах болжээ. Зарим судлаачид компьютерийн ёс зүй хэмээх нэр томъёог мэдээллийн ёс зүй хэмээн нэрлэх нь зүйтэй гэж үзэх болов.

Өөр нэг асуудал бол интернетийн гэмт хэрэг. Үүнийг хууль эрх зүйгээр төдийгүй, ёс суртахууны хэм хэмжээ, зарчмуудаар зохицуулах шаардлага өсч буй. Интернетийн гэмт хэргийн тодорхой жишээ нь : зохиогчийн эрх зөрчигдөх, вирус, хакеруудын үйл ажиллагаа, хувийн нууц алдагдах, мэйлийг нууц нэрээр илгээж, бусдыг гутаах, доромжлох, сүрдүүлэх, заналхийлэх, гүтгэх, данснаас мөнгө хулгайлах зэрэг болно. Эдгээр сөрөг үзэгдлүүдийг багасгахад дан ганц хуулиар зохицуулж чадахгүй.

Энд нэг гол арга зам бол хүүхэд залуучуудад интернетийн ёс зүйн мэдлэг, боловсрол, хүмүүжлийг олгох явдал юм. Үүний тулд юуны өмнө энэ чиглэлийн сургалтын төв байгуулах, мөн төрийн бус байгууллага ч байгуулж олон талт ажлыг зохион явуулах нь зүйтэй байна.

Их,дээд сургуулиудад оюутнуудыг дижитал мэдээллийн ертөнцөд үүсч болох ёс суртахууны зөрчлийг ялган салгаж мэдэрч чадах чадварт сургах, дижитал ертөнцөд хувь хүн болон хамт олноороо хариуцлагатай байх

¹⁵⁰ Gotterbarn.D.Computer ethics.1984

ухамсрыг төлөвшүүлэх,мэдээлэл-медиа орчин дох олон талт соёл,түүний уламжлалыг хүндэтгэх,энэ орчинд чөлөөтэй сэтгэн ярих диалогт оролцож сурах,өдөр тутмын мэдээллийн хэрэгцээгээ хангахдаа ёс зүйн энгийн ойлголт болон онолын үндсийг эзэмшин оролцох зэрэг чадварт сургах нь зайлшгүй хэрэгтэй байна.Ийм чадвар нь эрх чөлөө,шударга байдал,соёлын олон талт байдал,тэгш бололцоог өөрийн болгож дижитал ертөнцөд амьдрах иргэдийг бэлтгэхэд чухал юм.

Юуны өмнө интернет хэрэглээний ёс зүйн дүрэм, журмыг боловсруулж, мөрдүүлэх нь зүйтэй байна.Интернет хэрэглээний ёс зүйн үндсэн хэм хэмжээ ямар байх ёстой вэ?

Интернет хэрэглэгчийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх ёс суртахууны хэм хэмжээнүүд гэвэл :

- Мэдлэг бол хүн төрөлхтний өмч,тиймээс хүн бүрт нээлттэй,чөлөөтэй байх
- Мэдлэгт нэвтрэх зам чөлөөтэй байх
- Хүний эрх нь сүлжээнд холбогдсон ажлын байранд ч хангагдсан байх
- Хувь хүний болон нийгмийн тогтвортой хөгжлийн үндэс болсон соёлын олон талт байдлыг хүндэтгэх
- Бусдаас хараат бус мэдээллийн эх үүсвэрийн болон олон нийтийн мэдээллийн хэрэгслийн олон талт байдлыг хангах
- Техникийн нээлттэй стандарт ба техникийн бүтээгдэхүүний нээлттэй хэлбэр нь чөлөөт харилцаа холбоог хөгжүүлэх баталгаа гэдгийг баримтлах
- Хувь хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхолыг эрхэмлэн хүндэтгэх
- Хувь хүний нууцад хамаарах мэдээллийг задруулахгүй байх,
- Бодит нотолгоогүй, худал хуурмаг мэдээлэл түгээхийг цээрлэх,
- И-мэйл болон чатад бүдүүлэг үг, хэллэг хэрэглэхийг цээрлэх,
- Зохиогчийн эрхийг хүндэтгэх
- Бусдыг гүтгэх, мушгин гуйвуулахыг цээрлэх,
- Эх хэлний соёлыг эрхэмлэх,
- Элдэв хүчирхийлэл, садар самууныг сурталчлахгүй байх,
- Өөрийн үйлдлийн төлөө хариуцлага хүлээх чадвартай байх зэрэг болно.

Мэдээллийн ёс зүй болон интернетийн ёс зүйн асуудлаар эрдэмтэн мэргэд ,судлаачид та бүхнийг санал бодлоо хуваалцаж,хамтран ажиллахыг урьж байна.

Ном зүй

- Donn Parker.Information Ethics.1968
- Norbert Wiener.The Human Use of Human Beings.USA.1950
- Informations ethic.Fine Standart festimmung Rapael Capurro.International Review of Information Ethics (IRIE) .2004.
- Deborah.G.Johnson.Computer ethics.1985.
- Gotterbarn.D.Computer ethics.1984